



Үзүүлэлтүүд:

<p>ДНБ 1% 2016 оны IV-р улирлын байдлаар</p> <p>Хөдөө аж ахуйн салбар 13 хувь, үйлчилгээний салбар 10 хувиар өссөн нь нөлөөлөв.</p>	<p>ГШХО 1-р сард -36.4 сая ам.доллар</p> <p>Цэвэр ГШХО 1-р сарын байдлаар -36.4 сая ам.доллар өмнөх оны мөн үеэс 9.9 сая ам.доллараар буурав.</p>	<p>Төсвийн алдагдал -211.7 тэрбум төгрөг</p> <p>Төсвийн орлого 1034 тэрбум төгрөг, зарлага 1175 тэрбум төгрөг болж тэнцэл (211.7) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.</p>	<p>Инфляци 2.1%</p> <p>Өмнөх сараас 0.9 хувиар, оны эхнээс 2.1 хувь өсч өмнөх оны мөн үеэс 2.1 хувь өссөн байна.</p>	<p>Чанаргүй зээл 1187 тэрбум төгрөг</p> <p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 14.4 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 33.5 хувиар нэмэгдэж 1187 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 9.3% байна.</p>	<p>Валютын нөөц 1 тэрбум ам.доллар</p> <p>Монголбанкны валютын нөөц 1-р сард өмнөх оны мөн үеэс 16 хувь буюу 207 сая ам.доллараар буурч 1117 сая ам.доллар болов.</p>
<p>\$</p> <p>Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2478.29 ₮</p>	<p>1.009</p> <p>Орон сууцны үнийн индекс Өмнөх сараас 2.8%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 4.4%-иар буурав.</p>	<p>14%</p> <p>Монголбанкны бодлогын хүү</p>			

Монголын уламжлалт цагаан сарын баярыг 2017 оны 2-р сарын 27-ноос 3-р сарын 2-ний өдрүүдэд өргөн дэлгэр тэмдэглэж, бүх нийтээр амрав.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүллээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэббум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2015 он		2016 он		2017 оны 2-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	14.4	0.6	25.7	9.7	4.7	3.2
Төмрийн хүдэр	6.3	0.2	6.1	2.4	7.1	4.4
Зэсийн баяжмал	1.4	2.3	1.5	1.6	2.4	2.4
Нийт	22	3	33	14	14	10

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


ДНБ

ДНБ 2016 оны 4-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 16 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 65.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 1 хувиар өсөв. ДНБ-ий 1 хувиар өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 13 хувь, үйлчилгээний салбар 10 хувиар өссөн нь нөлөөлөв.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 45.9 хувиар, зарлага 21.5 хувь өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 211.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 46.7 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 14.4 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.




Валютын ханш

Хоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 454 төгрөг буюу 22.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 10 төгрөг буюу 0.4 хувиар буурч 2478.29 төгрөгөөр сулрав.



Инфляци


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 2-р сард өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өсч, өмнөх оны эцсээс 2.1 хувиар өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 2 хувь (сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 5.8 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 2.6 хувь, хувцас, бөс бараа, гутал 1.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УЦХ, Монголбанк

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2017 оны 1-р сарын байдлаар 1117 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 13.8 хувь буюу 179 сая ам.доллараар, өнгөрсөн оны мөн үеэс 16 хувь буюу 207 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс

2017 оны хоёрдугаар сард 54.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.7 сая үнэт цаас арилжсан нь өмнөх сараас гүйлгээ 2.8 хувиар, арилжсан үнэт цаас өмнөх оны мөн үеэс 44 хувь тус тус өссөн бол өмнөх сараас 93.6 хувь буурсан байна. ТОП-20 дундаж индекс 2017 оны хоёрдугаар сард 12122 нэгж болж, өмнөх сарынхаас 115 нэгжээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 328 нэгжээр өсчээ.



*Монголын хөрөнгийн бирж

Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) мөнгө өмнөх оны мөн үеэс 22 хувиар нэмэгдэж, өнгөрсөн сараас 3.1 хувиар нэмэгдэж 12 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 44.1 хувиар өсч, өмнөх сараас 23.8 хувиар өсч нийт мөнгөний 7.7 хувийг эзэлж байна.



Хадгаламж

Нийт хадгаламж 2017 оны 2-р сард 8.6 их наяд төгрөг болж өмнөх сараас 252 тэрбум төгрөг буюу 3 хувиар өсөв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 15.7 хувиар буюу 1143.1 тэрбум төгрөгөөр өсөв. Өмнөх сараас валютын хадгаламж 5.5 хувиар буюу 138.9 тэрбум төгрөгөөр буурсан бол төгрөгийн хадгаламж 17 хувиар буюу 390 тэрбум төгрөгөөр өсөв.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 2-р сард өмнөх сарынхаас 2.7 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 9.3 хувиар нэмэгдэж 12.7 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1187 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 14.4 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 33.5 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9.3% байна.



Ипотекийн зээл


2017 оны 1-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.4 хувь (16.6 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 17.5 хувь (600 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 4 их наяд төгрөгт хүрэв. Нэгдүгээр сард нийт 326 зээлдэгчид 38.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 89482-д хүрэв. 2017 оны нэгдүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.3 хувь нь төгрөгийн зээл, 0.7 хувь нь валютын зээл байна.



Гадаад худалдаа

Гадаад
худалдаа

2017 оны хоёрдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 1316 сая ам.доллар, үүнээс экспорт 825.2 сая ам.доллар, импорт 491 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 334.2 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 201 хувиар өсч, экспортын хэмжээ 190 хувиар өссөн бол импортын хэмжээ 220 хувиар өссөн байна. Импорт өмнөх оны мөн үеэс 138.9 сая ам.доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 56 сая ам.доллар, үүнээс дизелийн түлш 29 сая ам.доллар, автобензин 12.7 сая ам.доллараар, өссөн нь голлон нөлөөлжээ.



* Эх сурвалж УЦХ, Монголбанк

Гадаадын
шууд
хөрөнгө
оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2017 оны 1-р сард -36.4 сая ам.долларын сөрөг үр дүнтэй гарлаа. Харин өмнөх оны мөн үеэс 9.9 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад Монгол Улсаас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт 1.9 сая ам.доллар байсан бол Монгол Улсад -38.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.




* Эх сурвалж Монголбанк

Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2016 оны дөрөвдүгээр улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 24.2 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 3 хувь (135 сая ам.доллар), улсын нийт гадаад өр 2 хувь (479 сая ам.доллар)-иар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 20 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 10 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 34 хувийг бусад салбаруудын өр, 29 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



* Эх сурвалж Монголбанк

Сарын онцлох үйл явдал

2.18

Монгол Улс ОУВС-гийн “Extended fund facility” буюу “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-г хамрагдах болов. Манай улсад төсвийн болон төлбөрийн тэнцлийн гэсэн хосолсон хүндрэл үүссэн учраас энэхүү хөтөлбөрийг сонгосон талаар эрх баригчид мэдэгдсэн бөгөөд Монгол Улс нийт 5,5 орчим тэрбум ам.долларын хөнгөлөлттэй санхүүжилтийг донор орнуудаас авах юм. Хөтөлбөрийн хүрээнд нэгдүгээрт төсвийн бодлогыг авч хэрэгжүүлнэ. Хоёрдугаарт мөнгөний бодлого дээр цогц арга хэмжээ авна. Гуравдугаарт Монголбанкинд тухайлсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тохиролцов. Хөтөлбөр хэрэгжсэнээр 2017 онд эдийн засгийн өсөлт 0 хувиар, 2018 онд 1.8 хувиар, 2019 онд 8.1 хувиар өснө гэж тооцсон. Мөн хэрэглээний үнийн индекс, гадаад худалдааны тэнцэл, экспорт, импортыг шат дараатай нэмэгдүүлэх, валютын нөөцийг 2017 оны төгсгөл гэхэд 1.6 тэрбум, 2018 онд 2.7 тэрбум, 2019 онд 3.5 тэрбум, 2020 онд 3.8 тэрбумд хүргэж нэмэгдүүлнэ гэж мэлэглэв.